



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН АЛБА
УЛСЫН БАЙЦААГЧ, АУДИТОРЫН
ЗӨВЛӨМЖ

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндангийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173.
Утас/Факс: (976) 7032 4171, 7032 2625.
Цахим шуудан: sankhuu_audit_ov@yahoo.com,
Цахим хуудас: www.sankhuuhyanait.ov.gov.mn

2023.12.04 № 29/02/01
танай _____ -ны № _____ -Т

Зөвлөмж хүргүүлэх тухай

293
СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ

Б.Салмаа.
Г.Анхитор нарт
Аман Мисгийн Мэгдэл
Дэвчигэ Оюунбилэг
Милуур 2023.12.20кг

Дотоод аудитын 2023 оны төлөвлөгөөний дагуу Баянгол, Богд, Бүрд, Зүүнбаян-Улаан, Тарагт сумдын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж гүйцэтгэсэн бөгөөд аудитаар дараах нийтлэг асуудлууд илэрлээ. Үүнд:

1. Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журмын 2.4.Төлөвлөгөөг боловсруулахдаа дараах зарчмыг баримтална: 2.4.4. төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг арга хэмжээ тус бүрээр тусгасан байх гэсэн заалтыг Баянгол, Зүүнбаян-Улаан, Тарагт сумаас бусад сумд хэрэгжүүлж ажиллаагүй байгаа нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан сумын Засаг даргаар батлуулахдаа арга хэмжээ бүрд хэдэн төгрөг зарцуулахаар төсөвлөж байгаа төсвөө тавиагүй, биелэлтийг гаргахдаа хэдэн төгрөг зарцуулсан зэрэг төсөвтэй хамааралтай үзүүлэлтийг бичдэггүй зэргээс тухайн арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахад батлагдсан төсөв хүрдэг эсэхийг тооцож үзэх боломжгүй байдлыг үүсгэж байна.

2. Эрсдэлийн удирдлага, үнэлгээний ерөнхий ойлголт, ач холбогдол, үнэлгээ хийх арга аргачлалын талаар мэдлэг мэдээлэл муу, засаглах удирдлагаас энэ талаар чиглэл зааварчилгаа өгдөггүй, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхийг шаардсан хууль эрх зүйн зохицуулалт байхгүйгээс байгууллагын үйл ажиллагааны эрсдэлээ тодорхойлж, үнэлдэггүй, эрсдэлийн удирдлагын бодлого журам, эрсдэлийн эсрэг төлөвлөгөө боловсруулаагүй байгаа нь эрсдэлээ тодорхойлоогүй

892992007

нөхцөлд байгууллага зорилгодоо хүрэхэд саад бэрхшээл тулгарах, байгууллагын үнэ цэнэ буурах, төсөв санхүүгийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж байна.

3. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын хэрэгжилт хангалтгүй дотоод хяналтын нэгж эрсдэлд чиглэсэн хяналтыг хийдэггүй, жил бүр нэг чиглэлийн ор нэр төдий хяналтыг хийдэг.

4. Нягтлан бодогч болон хууль эрх зүйн мэргэжилтэнд сар бүр цалингийн нэмэгдэл, бүтэц, орон тоогоор батлагдаагүй компьютерын сүлжээ, IT хариуцсаны нэмэгдэл, хүний нөөц хариуцан ажилласны нэмэгдэл олгосон, төрийн албан хаасан хугацааны нэмэгдлийг илүү, дутуу олгосон, ээлжийн амралтын мэдэгдлийг буруу бичсэнээс ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчтай эцсийн тооцоог хийхгүй орхигдуулах зэрэг зөрчлүүд илэрч байгаа нь батлагдсан цалингийн сан хүрэлцэхгүй болох, улмаар шийдвэр гаргасан удирдах албан тушаалтан, ажил гүйлгээг хийдэг албан хаагчдад төлбөр торгууль тавигдах эрсдэлийг үүсгэж байна.

5. Захирамж, тушаал шийдвэрээр хөрөнгө зарцуулсан анхан шатны баримт дутуу, тухайн шийдвэрүүдээр худалдан авсан болон баяр наадмын бай шагналын аж ахуйн материалыг бараа материалын тайланд орлого аваагүй, ЗДТГ-ын дарга, санхүүгийн алба гүйлгээ хийх бүрд холбогдох анхан шатны баримттай тулган шалгадаг боловч төлбөрийн и-баримт, нэхэмжлэх, зарлагын баримт дутуу, албан томилолтын хуудсанд зөвшөөрсөн гарын үсэг, тамга тэмдэггүй байхад ажил гүйлгээг хийсэн, хяналтыг бүрэн гүйцэд тавьдаггүй.

Дээрхи илэрсэн нийтлэг асуудлуудтай уялдуулан дараах зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг зөвлөж байна. Үүнд:

1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө гаргах, биелэлтийг тайлагнахдаа төсөв, санхүүтэйгээ уялдуулан хийх.

2. Өөрийн байгууллагын эрсдэлээ тодорхойлж бүртгэлжүүлэх, бүртгэсэн эрсдэлээ үнэлж, албажуулах, эрсдэлийн эсрэг төлөвлөгөө боловсруулан ажиллах.

3. Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж, дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагааг эрс сайжруулах, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хийж, үр дүнг тооцож ажиллах.

4. Хууль тогтоомжид нийцээгүй нэмэгдлүүд олгодог байдлыг таслан зогсоож, цаашид олгохгүй байх.

5. Харилцагч иргэн, аж ахуйн нэгжээс төлбөрийн и-баримт, зарлагын баримт, нэхэмжлэхийг бүрэн гүйцэд авч хэвших, төлбөрийн и-баримт, зарлагын баримт,

нэхэмжлэх дутуу ажил гүйлгээг хийхгүй байх, үүнд ЗДТГазрын дарга, санхүүгийн алба хяналтыг тогтмол тавьж ажиллах.

6. Захирамж, тушаал шийдвэрээр хөрөнгө зарцуулахдаа нэхэмжлэх, зарлагын баримт, төлбөрийн и-баримтыг бүрэн гүйцэд авч, худалдан авсан шагналын бараа материал, бэлэг дурсгалын болон бусад холбогдолтой бараа материалуудыг эд хариуцагч нярвын тайланд орлого авахуулан зарцуулалтыг хийж байх, шууд зардалд бичиж байгаа үйл ажиллагааг таслан зогсоох.

7. Албан томилолтын мөнгийг тогтоосон дүрэм журмын дагуу олгох, илүү дутуу өгөхгүй байх, албан томилолтоор ажиллахыг зөвшөөрсөн ажлыг нь дүгнэн олгохыг зөвшөөрсөн гарын үсгийн бүрдлийг томилолтын мөнгө олгох бүрд тогтмол хянаж ажиллах.

ЗӨВЛӨМЖ БИЧСЭН
АУДИТОР, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЫН ДАМДОЛГОР

ХЯНАСАН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД
АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА

М.ЭРДЭНЭЧУЛУУН

